

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх
таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний
төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.11 дэх заалт, Авто тээврийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1."Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-г хавсралтаар тогтоосугай.

2.Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Б.Батбямба)-нд даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (.....)-нд, Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (.....)-нд тус тус даалгасугай.

5.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 21 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.БАЯР

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дүгээр тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ МӨРДӨХ ТАКСИНААС
БУСАД НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Нийтийн тээврийн хэрэгслийн нэр	Зорчих чиглэлийн нэр	Төлбөрийн хэмжээ /1 зорчигч төгрөгөөр/		Зорчих давтамж
			Насанд хүрсэн хүн	Сургуулийн насны хүүхэд	
1.	Автобус	Хот доторх болон хот орчмын зарим чиглэл	1000	200	Зориулалтын картаар өдөрт 4 удаа, бусад тохиолдолд зорчих бүрд
2.	Троллейбус		1000	200	
3.	Автобус	Санзайн эцэс-Их тамир-Зунжин худалдааны төв-7 буудал	1800	600	
4.	Автобус	Хүй 7 худаг-Эмээлт (хурган)-5 шар	1800	600	
5.	Автобус	Ногоон толгойт-Жаргалант тосгон-Хархорин	5200	1500	
6.	Автобус	Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-Сүхбаатарын талбайн төв зогсоол	15000	7500	
7.	Автобус	Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-5 шар”	10000	5000	
8.	Автобус	Тэрэлж-Офицеруудын ордон	5500	1500	
9.	Автобус	Туул тосгон-Биокомбинат-Яармагийн 3-р буудал	1600	600	
10.	Автобус	Налайх-Офицеруудын ордон	1800	600	

11.	Автобус	Улаанбаатар - Багануур	10000	5000	Зорчих бүрд
12.	Дунд болон бага оврын тээврийн хэрэгсэл		15000	7000	
13.	Автобус	"Багахангай- Дүнжингарав худалдааны төв"	8000	4000	

Жич: "Зориулалтын карт"-д нийтийн тээврийн хэрэгслээр зорчиход ашиглах албан ёсны төлбөрийн биет болон биет бус карт, төлбөрийн аппликейшн /QR/, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан сурагчийн картыг орно.

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ТӨСӨЛД
ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ МӨРДӨХ ТАКСИНААС БУСАД НИЙТИЙН
ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ/

АГУУЛГА

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРААНГУЙ.....	1
УДИРТГАЛ.....	2
НЭГ.НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ	3
1.1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	3
ХОЁР. АКТ ГАРГАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА, ЗОРИЛТ.....	4
2.1.ТУХАЙН АКТЫГ ГАРГАХ ҮНДЭСЛЭЛ.....	4
2.2.ТУХАЙН АКТЫГ ГАРГАХШААРДЛАГА.....	4
2.3.ЗОРИЛТЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ.....	4
ГУРАВ.ТУХАЙН АКТЫН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА ХАМААРАХ ХҮРЭЭ.....	5
3.1.АКТЫН ЕРӨНХИЙ НЭР	5
3.1.АКТЫН ЕРӨНХИЙ БҮТЭЦ.....	5
3.2.ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА.....	5
3.4.ХАМРАХ ХҮРЭЭ.....	5
ДӨРӨВ.АКТ ГАРСНЫ ДАРААХ ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛ НЬ АЛИВАА БАЙДЛААР ХӨНДӨГДӨХ БҮЛГИЙГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ.....	5
ХҮСНЭГТ1.ЭРХ, АШИГ СОНИРХОЛ НЬ ХӨНДӨГДӨЖ БОЛЗОШГҮЙ ЭТГЭЭДҮҮД	
ТАВ. АКТЫН ЗОХИЦУУЛАЛТ НЬ ХҮНИЙ ЭРХ, ЧӨЛӨӨ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ.....	5
БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ.....	5
ЗУРГАА. ДҮГНЭЛТ.....	6
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	7

**ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН НӨЛӨӨЛЛИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРААНГУЙ**

<p align="center">Үндэслэл шаардлага, зорилт</p>	<p><u>Үндэслэл:</u> Монгол Улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/233 дугаар тушаалаар батлагдсан “Зорчигч тээвэрлэлтийн 1 хүн.км-ийн жишиг тариф”, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Машин цагийн зардлын шинэчилсэн тариф”</p> <p><u>Шаардлага:</u> Нийслэлийн алслагдсан дүүргүүдийн нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх тарифыг батлах.</p> <p><u>Зорилт:</u> Нийслэлийн алслагдсан дүүргүүдийн нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.</p>
<p>Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлсон байдал</p>	<p>Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн эрх ашгийг төлөөлж Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Улаанбаатар-Багахангай дүүргийн хооронд нийтийн тээврийн үйлчилгээ нэвтрүүлэх талаар 2024.03.30-ны өдрийн 03/222 тоот албан бичиг, 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 1/153 тоот албан бичиг, 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 02/766 тоот албан бичиг, Багануур даргын Засаг даргын 2024 оны 11 сарын 11-ний өдрийн 08/1101 тоот албан бичиг, Буянт хүлгийн жолоо ХХК-ийн албан хүсэлт, холбогдох судалгааг үндэслэсэн.</p>
<p>Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх</p>	<p>Өрсөлдөөнийг хязгаарласан, бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн зохицуулалт агуулаагүй болно.</p> <p>Хууль бус такси үйлчилгээ эрхлэгч иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоож, саад болно.</p>
<p>Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх</p>	<p>“Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 26 дугаар тогтоол</p>
<p>Хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо</p>	<p>Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар хариуцан зохион байгуулна.</p>

УДИРТГАЛ

Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4 дэх хэсэгт заасныг үндэслэн Хууль зүйн сайдын 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/222 тоот тушаалын хавсралтаар баталсан "Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал"-ын дагуу "Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох тухай" тогтоолийн төсөлд дараах нөлөөллийн шинжилгээг хийв.

Үүнд:

1. Акт гаргах үндэслэл, шаардлага, зорилт;
2. Тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ;
3. Акт гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлгийг тодорхойлох;
4. Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх;
5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх;
6. Актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо.

Журмын төсөлд нөлөөллийн шинжилгээ хийхдээ тухайн зохицуулалтуудыг хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй субъектүүд нийтээр дагаж мөрдөх боломжтой, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй эсэх, тухайн шийдвэрийг хэрэгжүүлснээр тавьсан зорилгод хүрч чадах эсэх, холбогдох хуулийн агуулга, зорилго хүрээнд нийцэж байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон.

НЭГ. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.1. Ерөнхий мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Засаг даргатай уулзалт зохион байгуулж нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэж бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

БҮ:17 Улаанбаатар-Багануур чиглэлийн замналд өөрчлөлт оруулж Дүнжингарав худалдааны төвөөр буцаж эргүүлэх төлөвлөлтийн санал боловсруулсан.

Одоогийн үйлчилгээ үзүүлж буй ЮНайтэд бра ХХК нь бүртгэлийн санд 2013 оны 2, 2014 оны 1, нийт 3 жуулчин автобустай өдөрт 1 гаралтаар үйлчилгээ үзүүлж байгаа ба цаашид цахим төлбөрийн төхөөрөмж суулган үйлчилгээг үргэлжлүүлэх боломжтой.

Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/93 дугаар тушаалаар Багахангай дүүргийн нийтийн тээврийн үйлчилгээг Нийтийн тээврийн газрын чиг үүрэгт

шилжүүлсэнтэй холбогдуулан тус газрын даргын 2020.07.09-ний өдрийн А/57 дугаар тушаалаар БҮ:18 Улаанбаатар-Багахангай чиглэлийн үйлчилгээг эхлүүлсэн.

Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2024.03.25-ны өдрийн 03/222 дугаартай албан бичгээр тус чиглэлийг Тэнгэр худалдааны төв, Нарантуул ОУ-ын худалдааны төв хүртэл явуулах хүсэлт ирүүлсэн хэдий ч замын хөдөлгөөний ачаалал, автобус эргэх эцсийн зогсоолын хүртээмж, цагийн хуваарийн дагуу үйлчлэх боломжийг судлан үзэж Дүнжингарав худалдааны төвөөр буцаж эргүүлэх төлөвлөлтийг боловсруулсан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан "Машин цагийн зардлын шинэчилсэн тариф"-т алслагдсан дүүргүүдэд шинээр эхлүүлэх нийтийн тээврийн чиглэлүүдийн үйлчилгээний үнэ, тарифыг батлаагүй бөгөөд дээрх чиглэлүүдийн үнэ тарифыг батлуулахаар тогтоолын төслийг боловсруулсан.

ХОЁР. АКТ ГАРГАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА, ЗОРИЛТ

2.1. Тухайн актыг гаргах үндэслэл:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан "Машин"-т алслагдсан дүүргүүдийн нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифыг тусган шинэчлэн батлуулах.

Эдгээр зохицуулалтыг **Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.**

Д/д	Нийтийн тээврийн хэрэгслийн нэр	Зорчих чиглэлийн нэр	Төлбөрийн хэмжээ /1 зорчигч төгрөгөөр/		Зорчих давтамж
			Насанд хүрсэн хүн	Сургуулийн насны хүүхэд	
1.	Автобус	Хот доторх болон хот орчмын зарим чиглэл	1000	200	Зориулалтын картаар өдөрт 4 удаа, бусад тохиолдолд зорчих бүрд
2.	Троллейбус		1000	200	
3.	Автобус	Санзайн эцэс-Их тамир-Зунжин худалдааны төв-7 буудал	1800	600	
4.	Автобус	Хүй 7 худаг-Эмээлт (хурган)-5 шар	1800	600	
5.	Автобус	Ногоон толгойт-Жаргалант тосгон-Хархорин	5200	1500	
6.	Автобус	Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-Сүхбаатарын талбайн төв зогсоол	15000	7500	

7.	Автобус	Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-5 шар”	10000	5000	
8.	Автобус	Тэрэлж-Офицеруудын ордон	5500	1500	
9.	Автобус	Туул тосгон-Биокомбинат-Яармагийн 3-р буудал	1600	600	
10.	Автобус	Налайх-Офицеруудын ордон	1800	600	
11.	Автобус	Улаанбаатар - Багануур	10000	5000	
12.	Дунд болон бага оврын тээврийн хэрэгсэл		15000	7000	Зорчих бүрд
13.	Автобус		“Багахангай-Дүнжингарав худалдааны төв”	8000	

2.2.Тухайн актыг гаргах шаардлага:

2.2.1.Шинээр нэвтрүүлэх чиглэлүүдийн эргэлтийн урт Х:17 чиглэл 271км, Х:18 чиглэл 176км, Х:19 чиглэл 95,4 км, Х:20 чиглэл 85 км тус тус байна. Эдгээр чиглэлүүдэд нийтийн тээврийн үйлчилгээ нэвтрүүлэхэд үйлчилгээний үнэ тарифийг шинэчлэн тогтоох хэрэгцээ бий болсон.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Машин цагийн зардлын шинэчилсэн тариф”-ийн жагсаалтад эдгээр чиглэлүүд тусгагдаагүй болно.

2.3. Зорилтыг тодорхойлсон байдал:

Шинээр нэвтрүүлэх нийтийн тээврийн үйлчилгээний Х:17, Х:18, Х:19, Х:20 чиглэлүүдийн үйлчилгээний үнэ тарифийг шинэчлэн тогтоох.

ГУРАВ. ТУХАЙН АКТЫН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА ХАМРАХ ХҮРЭЭ

3.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тогтоолыг шинэчлэн батлах

3.2. Актын бүтэц:

Нэг. Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох

Хоёр. Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ

3.3. Зохицуулах харилцаа

Нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай дүүргүүдэд шинээр эхлүүлэх нийтийн тээврийн чиглэлүүд, Чингис хаан олон улсын нисэх буудлын чиглэлийн үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох бөгөөд дээрх чиглэлүүдийн үнэ тарифыг тогтоох.

3.4. Хамрах хүрээ:

Багануур, Багахангай дүүргийн иргэд, Чингис хаан олон улсын нисэх буудлын чиглэлд нийтийн тээврээр үйлчлүүлэх иргэд, Эдгээр чиглэлд үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж байгууллагууд.

ДӨРӨВ. АКТ ГАРСНЫ ДАРАА ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛ НЬ АЛИВАА БАЙДЛААР ХӨНДӨГДӨХ БҮЛГИЙГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Тогтоолын төслийг алслагдсан дүүргүүдийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар уламжлан ирүүлсэн болон тус газарт ирүүлсэн иргэдийн санал, хүсэлт, хүсэлтэд тулгуурласан.

Хүснэгт 1. Эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдүүд

№	Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Тогтоолоор хүлээх үүрэг хариуцлага
1.	Тус дүүргүүдэд албан ёсны үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллага	- Автотээврийн тухай хууль - Нийтийн тээврийн газартай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ
2.	Хууль бус такси үйлчилгээ эрхлэгч иргэд	

ТАВ.АКТЫН ЗОХИЦУУЛАЛТ НЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тогтоол батлагдсанаар нийслэлийн алслагдсан дүүргүүдэд нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх боломж бүрдэх бөгөөд, хууль бус тээврийн үйлчилгээг таслан зогсоох боломж бүрдэнэ.

Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэхийг ерөнхий асуултуудад хариулах замаар тодорхойлов.

Нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
	Тийм	Үгүй	
Хүний эрх, чөлөө ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх;		√	
Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарласан бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх;	√		
Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	√		

Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх;		√	
Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх;		√	
Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох эсэх;		√	
Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллагад захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгож байгаа эсэх;		√	
Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэх эсэх		√	
Бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх;		√	
Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх;		√	

ДҮГНЭЛТ

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Засаг даргатай уулзалт зохион байгуулж нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэж бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

БҮ:17 Улаанбаатар-Багануур чиглэлийн замналд өөрчлөлт оруулж Дүнжингарав худалдааны төвөөр буцаж эргүүлэх төлөвлөлтийн санал боловсруулсан.

Одоогийн үйлчилгээ үзүүлж буй Юнайтэд бра ХХК нь бүртгэлийн санд 2013 оны 2, 2014 оны 1, нийт 3 жуулчин автобустай өдөрт 1 гаралтаар үйлчилгээ үзүүлж байгаа ба цаашид цахим төлбөрийн төхөөрөмж суулган үйлчилгээг үргэлжлүүлэх боломжтой.

Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/93 дугаар тушаалаар Багахангай дүүргийн нийтийн тээврийн үйлчилгээг Нийтийн тээврийн газрын чиг үүрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан тус газрын даргын 2020.07.09-ний өдрийн А/57 дугаар тушаалаар БҮ:18 Улаанбаатар-Багахангай чиглэлийн үйлчилгээг эхлүүлсэн.

Багахангай дүүргийн Засаг даргын тамгын газраас 2024.03.25-ны өдрийн 03/222 дугаартай албан бичгээр тус чиглэлийг Тэнгэр худалдааны төв, Нарантуул ОУ-ын худалдааны төв хүртэл явуулах хүсэлт ирүүлсэн хэдий ч замын хөдөлгөөний ачаалал, автобус эргэх эцсийн зогсоолын хүртээмж, цагийн хуваарийн дагуу үйлчлэх боломжийг судлан үзэж Дүнжингарав худалдааны төвөөр буцаж эргүүлэх төлөвлөлтийг боловсруулсан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Машин цагийн зардлын шинэчилсэн тариф”-т алслагдсан дүүргүүдэд шинээр эхлүүлэх нийтийн тээврийн чиглэлүүдийн үйлчилгээний үнэ, тарифыг батлаагүй бөгөөд дээрх чиглэлүүдийн үнэ тарифыг батлүүлэхээр тогтоолын төслийн боловруулсан.

Эдгээр зохицуулалтыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

Д/д	Нийтийн тээврийн хэрэгслийн нэр	Зорчих чиглэлийн нэр	Төлбөрийн хэмжээ /1 зорчигч төгрөгөөр/		Зорчих давтамж
			Насанд хүрсэн хүн	Сургуулийн насны хүүхэд	
1.	Автобус	Хот доторх болон хот орчмын зарим чиглэл	1000	200	Зориулалтын картаар өдөрт 4 удаа, бусад тохиолдолд зорчих бүрд
2.	Троллейбус		1000	200	
3.	Автобус	Санзайн эцэс-Их тамир-Зунжин худалдааны төв-7 буудал	1800	600	
4.	Автобус	Хүй 7 худаг-Эмээлт (хурган)-5 шар	1800	600	
5.	Автобус	Ногоон толгойт-Жаргалант тосгон-Хархорин	5200	1500	
6.	Автобус	Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-Сүхбаатарын талбайн төв зогсоол	15000	7500	
7.	Автобус	Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-5 шар”	10000	5000	
8.	Автобус	Тэрэлж-Офицеруудын ордон	5500	1500	
9.	Автобус	Туул тосгон-Биокомбинат-Яармагийн 3-р буудал	1600	600	
10.	Автобус	Налайх-Офицеруудын ордон	1800	600	
11.	Автобус	Улаанбаатар - Багануур	10000	5000	
12.	Дунд болон бага оврын тээврийн хэрэгсэл		15000	7000	
13.	Автобус		“Багахангай-Дүнжингарав худалдааны төв”	8000	

Ашигласан материал:

1. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль
2. Захиргааны ерөнхий хууль
3. Автотээврийн тухай хууль
4. 2006 оны Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
5. Монгол улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/233 дугаар тушаалаар батлагдсан "Зорчигч тээвэрлэлтийн 1 хүн.км-ийн жишиг тариф",

Шинээр нээгдэх чиглэлийн эдийн засаг, үр ашгийн тооцоолол

Үндэслэл:

- Монгол Улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/233 дугаар тушаалаар батлагдсан “Зорчигч тээвэрлэлтийн 1 хүн.км-ийн жишиг тариф”,
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Машин цагийн зардлын шинэчилсэн тариф”

Х:17 Улаанбаатар /Дүнжингарав худалдааны төв/- Багануур /Хэрлэн худалдааны төв/

- ✓ Эргэлтийн урт 271 км
- ✓ Эргэлтийн хугацаа 325 минут
- ✓ Өдөрт гүйцэтгэх рейс 1
- ✓ 1 цагийн батлагдсан тариф 80807 төгрөг

Монгол Улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/233 дугаар тушаалаар батлагдсан “Зорчигч тээвэрлэлтийн 1 хүн.км-ийн жишиг тариф”-ийн дагуу 1 км-ийн тарифийг:

- 75 төгрөгөөр тооцоход 10162,5 төгрөг,
- 150 төгрөгөөр тооцоход 20325 төгрөг байхаар байна.

Өдөрт 1 рейс гүйцэтгэж 8 цаг ажиллана гэж тооцоход өдөрт 646,5 мянган төгрөгийн машин цагийн зардал гарахаар байна.

Энэ чиглэлд Юнайтэд бра ХХК автобусаар 10 000 төгрөгөөр, хувийн такси 13 500 төгрөгөөр үйлчилгээ үзүүлж байна.

Одоо үйлчилж байгаа тариф болон жишиг тарифийг харгалзан нэг талдаа том хүн 10 000, хүүхэд 5000 төгрөгөөр тогтоох санал боловсруулсан.

Дээрх үнээр үйлчилгээ үзүүлэхэд автобусны суудал дүүргэлт 78 хувьтай буюу насанд хүрсэн зорчигч 30, хүүхэд 5, нийт 35 зорчигчтой үйлчилгээнд ажиллахад 1 рейсэнд 650,0 мянган төгрөгийн орлого олж, зардлаа нөхөх тооцоо гарч байна.

Х:18 “Багахангай-Дүнжингарав худалдааны төв”

- ✓ Эргэлтийн урт 176 км
- ✓ Эргэлтийн хугацаа 212 минут
- ✓ Өдөрт гүйцэтгэх рейс 1
- ✓ 1 цагийн батлагдсан тариф 80807 төгрөг

Монгол Улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/233 дугаар тушаалаар батлагдсан “Зорчигч тээвэрлэлтийн 1 хүн.км-ийн жишиг тариф”-ийн дагуу 1 км-ийн тарифийг:

- 75 төгрөгөөр тооцоход 6600 төгрөг,
- 150 төгрөгөөр тооцоход 13200 төгрөг байхаар байна.

Өдөрт 1 рейс гүйцэтгэж 5 цаг ажиллана гэж тооцоход өдөрт 404,0 мянган төгрөгийн машин цагийн зардал гарахаар байна.

Энэ чиглэлд хувийн такси 10 000 төгрөгөөр үйлчилгээ үзүүлж байна.

Одоо үйлчилж байгаа тариф болон жишиг тарифийг харгалзан нэг талдаа том хүн 8 000, хүүхэд 4000 төгрөгөөр тогтоох санал боловсруулсан.

Дээрх үнээр үйлчилгээ үзүүлэхэд автобусны суудал дүүргэлт 78 хувьтай буюу насанд хүрсэн зорчигч 30, хүүхэд 5, нийт 35 зорчигчтой үйлчилгээнд ажиллахад 1 рейсэнд 520.0 мянган төгрөгийн орлого олж, зардлаа нөхөх тооцоо гарч байна.

Х:19 “Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал- Сүхбаатарын талбайн төв зогсоол”

- ✓ Эргэлтийн урт 95.4 км
- ✓ Эргэлтийн хугацаа 114 минут
- ✓ Өдөрт гүйцэтгэх рейс 2
- ✓ 1 цагийн батлагдсан тариф 80807 төгрөг

Өдөрт 2 рейс гүйцэтгэж 8 цаг ажиллана гэж тооцоход өдөрт 646,5 мянган төгрөгийн машин цагийн зардал гарахаар байна.

Одоо үйлчилж байгаа такси үйлчилгээний тариф болон зорчигч урсгалыг харгалзан нэг талдаа том хүн 15 000, хүүхэд 7500 төгрөгөөр тогтоох санал боловсруулсан.

Дээрх үнийн тарифаар үйлчилгээ үзүүлэхэд автобусны суудал дүүргэлт 27 хувьтай буюу насанд хүрсэн зорчигч 10, хүүхэд 2, нийт 12 зорчигчтой үйлчилгээнд ажиллахад 1 рейсэнд 330.0 мянган төгрөг, 2 рейсэнд 660.0 төгрөгийн орлого олж, зардлаа нөхөх тооцоо гарч байна.

Х:20 Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал-5 шар”

- ✓ Эргэлтийн урт 85.0 км
- ✓ Эргэлтийн хугацаа 120 минут
- ✓ Өдөрт гүйцэтгэх рейс 2
- ✓ 1 цагийн батлагдсан тариф 80807 төгрөг

Өдөрт 2 рейс гүйцэтгэж 6 цаг ажиллана гэж тооцоход өдөрт 484,8 мянган төгрөгийн машин цагийн зардал гарахаар байна.

Одоо үйлчилж байгаа такси үйлчилгээний тариф болон зорчигч урсгалыг харгалзан нэг талдаа том хүн 10 000, хүүхэд 5000 төгрөгөөр тогтоох санал боловсруулсан.

Дээрх үнийн тарифаар үйлчилгээ үзүүлэхэд автобусны суудал дүүргэлт 27 хувьтай буюу насанд хүрсэн зорчигч 10, хүүхэд 2, нийт 12 зорчигчтой үйлчилгээнд ажиллахад 1 рейсэнд 270.0 мянган төгрөг, 2 рейсэнд 540.0 төгрөгийн орлого олж, зардлаа нөхөх тооцоо гарч байна.

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР